

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор Г
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.2, 15.3.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан ”Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д дараах агуулгатай 2.25¹, 2.26¹ дэх заалтыг нэмсүгэй:

1/ “2.25¹. Хэрэв өргөдөл гаргагч нь банк бол Банкны тухай хуулийн 6.4-т заасны дагуу даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэхэд татгалзахгүй тухайгаа мэдэгдэж Монголбанкнаас Хороонд ирүүлсэн албан бичиг.

2/ 2.26¹. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь даатгалд жил бүр даатгуулах ба мэргэжлийн хариуцлагын даатгалын хэмжээний доод хязгаар 50.0 сая төгрөг байна.”.

2. Мөн дээрх журмын 2.24 дэх заалтын “2.11.8” гэснийг “2.11.7” гэж өөрчилсүгэй.

3. Мөн журмын 2.17, 2.18, 2.20, 2.22 дахь заалтуудыг дараах агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “2.17.Даатгалын зуучлагч компанийг байгуулсан, эсхүл Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк байх;

2/ 2.18.Даатгалын зуучлагч хуулийн этгээдийн дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглох бөгөөд дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь даатгалын ангилал /ердийн, урт хугацааны/ тус бүрд 10.0 сая төгрөг байх;

3/ 2.20.Өргөдөл гаргагчийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч болон удирдах ажилтнууд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд байх;

4/ 2.22.Дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлосон байх;”.

4. Тогтоолд нэмэлт өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН